

ОЛОН УЛСЫН ХАРИЛЦААН ДАХЬ СОЁЛ ИРГЭНШЛИЙН АСУУДАЛД

Г.Баасанхүү*

Олон улсын харилцааны хамгийн тогтвортой бөгөөд хурц систем болох “хүйтэн дайн”-ы хоёр туйлт систем задран унасны дараахан судлаачдын хувьд онолын хямралын үе эхэлсэн гэж үзэж болно.

1993 онд Америкийн эрдэмтэн Самуэл Хантингтоны “Соёл иргэншлүүдийн мөргөлдөөн үү?”¹ хэмээх алдарт өгүүлэл нийтлэгдэн өнөөдрийг хүрсэн олон улсын харилцааны онолын том маргааныг дэгдээж, судалгааны шинэ хандлагыг гаргасан юм. Энэ нь “хүйтэн дайн”-ы дараах үеийн даяаршин нягтарч буй улс хоорондын харилцааг тайлбарлах хамгийн оновчтой гэж үзэж болохоор үзэл баримтлал байсан бөгөөд тиймдээ ч өгүүлэл хэвлэгдсэнээс хойш 10 гаран жил өнгөрч олон улсын харилцаа хөгжлийн тодорхой хувьслуудыг үзээд байгаа ч олон улсын харилцааг тайлбарлах соёл иргэншлийн хандлага нь улам нөлөө бүхий онолын хандлага болсоор ирлээ.

Хэдий олон улсын харилцааг XX зууны сүүлээр соёл иргэншилтэй холбон тайлбарлахыг оролдсон нь үнэн боловч үнэндээ төрт улсууд өөр хоорондоо харилцаж эхэлсэн эрт цагаас эхлэн улс хоорондын харилцаанд соёл иргэншлийн нөлөө хүчтэй байсаар ирсэн билээ. Олон улсын харилцаан дахь хамгийн чухал асуудал болох дайн ба энхийн асуудал, тусгаар улс хоорондын харилцаа, түншлэл, эвсэл, дайсагнал, худалдаа зэрэгт их бага хэмжээгээр ямагт соёл иргэншлийн нөлөө байсаар ирсэн юм.

Олон улсын харилцааны хувьд соёл иргэншлийн онолын үзэл, номлолууд нь тодорхой нэг соёл иргэншлийн адилтгах нийтлэгээс үүдэлтэй ба улс хоорондын харилцаа холбоо нь “бид нар - та нар - тэд нар” гэсэн соёл иргэншлийн системтэй холбоотой гэж үзнэ. Бүх зүйл хэлнээс эхэлдэг. “Бид” гэж байхад төвийг сахисан “та нар” байгаад, бас харийн, дайсагнасан цэнэг бүхий “тэд нар” байна гэж үзнэ. Энэ утгаар авч үзвэл олон улсын харилцаа нь түншлэл, дайсагналаас тогтох ба аль

* МУИС-ийн ОУХС-ийн багш, докторант

¹ S.Huntington. "The clash of civilizations?" — "Foreign Affairs", Summer 1993

аль нь харилцан нэгнээс хамааралтай холбоог үүсгэж байдаг гэж үзэж болох юм. Тэр бүрд улс хоорондын харилцаанд соёл иргэншлийн хүчин зүйл нөлөөлсөөр байдаг. Улс гүрнүүд ойртон нягтарч түншлэлд багтах, цэргийн эвсэл байгуулах, идэвхтэй худалдаа, эдийн засгийн харилцаа хөгжүүлэхэд зөвхөн газар зүйн таатай байршил зэрэг геополитикийн хүчин зүйлс нөлөөлөхөөс илүүтэй шашин нэг байх, амьдралын үнэт зүйлсийн нийтлэг, түүх угсааны болон хэл соёлын ойр дөт байдал зэрэг нэн хүчтэй нөлөөлдөг гэж үзэж болно. Мөн улс хоорондын дайны тодорхой шалтгаан нь соёл иргэншлийн ялгаатай байдал байсаар ирсэн.

Вестфалиас Версаль-Вашингтоны систем (1648-1919) хүртэлх олон улсын харилцааны бүх түүхэн системүүд нь Европ төвтэй байсан бөгөөд үнэндээ анхны Ази, Номхон далай дахь Вашингтоны дэд систем (1921-1939) маань ч өрнөдөд тулгуурласан байсан. Европчууд дэлхийн бусад улсаас эдийн засгийн хөгжлөөр нэг шат түрүүнд явж ирсэн байдал нь эргээд өрнөдийн соёл иргэншилтэй бусад соёл иргэншлүүдийг харьцуулах, түүнээс доорд тавих шалтгаан болсон гэж үзэж болно. Соёл иргэншлийн шалгуур ч бодит шинжлэх ухааных байхаасаа илүүтэй өрнөдийнхтэй шууд жишсэн харьцуулалт байв. Энэ байдал нь эргээд олон улсын харилцааны хөгжилд хүчтэй нөлөөлж баруун Европоос хаяагаа тэлж эхэлсэн олон улсын харилцаанд нэгдэн орох улс үндэстнүүдэд соёл иргэншлийн шалгуур тавих буюу хүчээр өрнөджүүлэх, европжуулах үзэгдэл газар авсан юм. Өөрөөр хэлбэл, олон улсын харилцааны шинэ “тоглогч” бүрийг их бага ямар нэг байдлаар өрнөдийн соёл иргэншилд уях бодлого явсаар ирсэн бөгөөд өнөөдөр ч энэ байдал хадгалагдан үлджээ.

Аливаа хүчирхэг гүрэн, дэлхийн бодлогыг тодорхойлогч их гүрнүүд нь түүхэн тодорхой үед олон улсын харилцааг тодорхойлж байхдаа өөрийн соёл иргэншлийн стандартад бусдыг тэнцүүлэх, бусад улс үндэстнийг уях бодлого явуулсаар ирсэн (VIII зууны арабууд, XIII зууны монголчууд, XVI-XVIII зууны европчууд гэх мэт). Түүн лугаа XVII зуунаас хойш дэлхийн II дайн хүртлэх урт хугацаанд европчууд, эдүгээ АНУ өөрийн буюу өрнөдийн үнэт зүйл, соёл иргэншилдээ уях бодлого явуулж байна.

Гэвч түүхэнд өрнөд шиг тайван замаар буюу соёл, соёл иргэншлийн хүчээр дэлхийг он удаан хугацаанд ноёрхож ирсэн соёл иргэншил үгүй юм. Тэд дорны соёл иргэншлүүдийн шууд дайтан хүч хэрэглэх замаар буулган авах “дайралт”-аас

хэд дахин сөрөг үр дагавартай аймшигт “соёлын довтолгоо”-г явуулсаар ирсэн гэж хэлж болно. Соёл иргэншлийн хүчин зүйлтэй холбогдон “соёлт улс ба зэрлэгүүд”, “хоцрогдсон бүдүүлгүүд” гэх ойлголт газар авсан бөгөөд өрнөдийн соёл иргэншлийн үнэт зүйл, шалгуурд харшлагч улс гүрнүүдийг дотоод хэрэгт нь хөндлөнгөөс оролцох, хүч хэрэглэн засан тохинуулах замаар “соёлт” болгох буюу номхруулах бодлого нь олон улсын харилцаанд өрнөдийн соёл иргэншлийн үзүүлсэн хамгийн том нөлөө гэж үзэж болно.

Орчин цагт олон улсын харилцаанд эсрэг тэсрэг хоёр үзэгдэл ажиглагдаж байна. Үүнд:

1. Нэг талаас, харилцан нэгнээс улам бүр хамаарах байдал өсөн нэмэгдэж, дэлхий нийтийг глобалчлал буюу даяаршил бүрхэж, мэдээллийн технологи, харилцаа холбоо урьд байгаагүй хурдтайгаар хөгжиж, эдийн засаг, санхүүгийн хувьд улс үндэстэн хоорондоо маш нягт, шууд холбоотой болж, энэ бүгд нь дэлхийн улс гүрнүүдийн төв рүү тэмүүлэх хөдөлгөөний нэг чиг болж байна;
2. Нөгөө талаас шинэчлэл нэрийн дор өрнөджүүлэх бодлогын эсрэг, даяаршил нэрийн доор өрнөдөөс хамааралтай болгож буй универсалчлалд (нэгэн хэв загварт цутгах, уях бодлогын эсрэг) хариу болгож, төвөөс зугатах үзэгдэл идэвхжиж байна.

Америкийн соёл улам бүр өдөр тутмын амьдралд түрэхийн хэрээр, улс үндэстнүүд түүнээс зайлсхийх, өөрийн соёл иргэншлийн үнэт зүйлийг илүүд тавих, түүхэн-уламжлал, амьдралын үнэт зүйлсээ сэргээхийг оролдож байна. Улс үндэстнүүд соёл иргэншлийн хил хязгаарын хүрээндээ нэг эх, нэг хувь заяа, адилтгах ерөнхий нийтлэгүүдээ нэгтгэх, нийтлэг өвөө хөгжүүлэн сэргээхийг эрмэлзэх болжээ. Жишээ нь, өрнөдийн соёл иргэншил дотооддоо хагаралд орж, эх газрын европчууд, америкийн соёл иргэншлээс ялгагдах онцлогоо эрэлхийлэх болсны нэг тод илрэл нь Европын Холбоонд ажиглагддаг. Газар зүйн их нээлтүүдээс хойш олон улсын харилцааг бүхэлд нь хянаж байсан Европын үндэсний улсууд өөрсдийн эхэлсэн 2 их дайныхаа золиос болж хөгжлийн эрч хүчээ алдаад зогсохгүй давамгайлагч байр сууриа зуугаадхан жилийн өмнө өөрсдийнх нь эрхшээлд байсан колони асан Америкт алдсан билээ. Нөгөөтэйгүүр хэдэн зууны туршид дэлхийн бодлогодоо баримталж байсан хүчээр өрнөджүүлэх

бодлогынхоо дүнд тэд өөрийн соёл иргэншлийн бусдаас ялгагдах онцлогоо алдаж үндсэндээ хэн ч биш болсон гэж болно. Тэдний хувьд энэ дорой байдлаас нэр төртэй гарах цорын гэж болох гарц нь Пан Европын үзэл доор, эх газрын соёл иргэншилдээ нэгдэх явдал байв. Зуун зууны их сэтгэгчид, улс төрийн зүтгэлтнүүдийн ярьж асан нэгдсэн өрнөдийн тухай санаа ХХ зуунд сая Европын Холбоогоор биеллээ олсон гэж болно. Хэдий тэд дотооддоо үндэстэн хоорондын “аягүйцэл”-ээс эхлэн худалдаа наймааны тариф хүртэл хэзээ ч бүрэн шийдвэрлэх аргагүй олон тооны зөрчилтэй байгаа боловч тэднийг нэгдмэл нэг соёл иргэншлийн эх нэгтгэж байдаг юм. Тэднийг америк, оросуудаас ялгах олон нийтлэг, тухайлбал, соёлын нэг эх болох грек-ромын өв, үнэт зүйлийн нэг тогтолцоо буюу загалмайтны шашин, сэргэн мандалт, соён гэгээрүүлэгчдийн түүх Холбоон дотор нь нэгтгэж байдаг билээ.

Ер нь соёл иргэншлийн асуудлуудыг судалж байхад аливаа соёл иргэншлийг хувь хүнд, цаг хугацаа, орон зайнд хэрхэн хандаж буйгаар нь ялгаж, харьцуулан таньж болно. Жишээ нь өрнөд ба дорнод хэмээх соёл иргэншлийн хамгийн түгээмэл ангиллыг дээрх байдлаар харьцуулан үзвэл,

1. *Хувь хүнд хандах хандлагаар* өрнөдийн соёл иргэншил, загалмайтны шашин нь үнэт зүйлсийн хувьд хувь хүнийг гол төв болгон авч үзсээр ирсэн нь ажиглагддаг. Загалмайтны шашны бурхад нь хүн төрхтэй. Энэ нь эргээд сэтгэлгээнд нөлөөлж, хувь хүний бурханы өмнө хүлээх шууд хамааралтай үүргийн сонголт хийгээд, тухайн хүнд тодорхой хүсэл зоригийг сонгох эрх чөлөөг олгож, хувь хүний өөрөө өөрийгөө үнэлэх байдал өссөн. Ингэж өрнөдийн соёлын нэгэн үнэт зүйл болох хувь хүний эрх, эрх чөлөө үүссэн гэж үзэж болно. Хүн, түүний язгуур эрх, эрх чөлөөнөөс нийтийн гэрээний тухай санаа үүссэн аж. Энэ нь эргээд нийгэмд эзлэх хувь хүний биеэ даасан, өөрөө өөрийнхөө хариуцлагыг ухамсарласан сэтгэлгээг хөгжүүлсэн гэж болно. Тэгвэл дорны энэтхэгийн, буддын, лалын, зүүн Азийн соёл иргэншлүүдийн хувьд хувь хүн нийгэм дотор төрсөн цагаасаа эхлэн бичигдсэн байдаг. Нийгэм хувь хүний хэзээд түрүүнд оршдог. Гэр бүл, каст, төр улс бүгд хувь хүнээс илүү байдаг. Дорны хувьд нийгэм, хамт олон, гэр бүл гэдэг бол хувь хүнээс хэд илүү үнэт зүйл байдаг.

Иймд хувь хүн хэзээд бусдын өмнө хариуцлага үүрэг хүлээж, өөрийн эрх чөлөөнөөс нийгмээ түрүүнд тавьсан сэтгэлгээтэй болжээ.

2. Цаг хугацааны хувьд өрнөдийн соёл иргэншилд бие хүн цаг хугацааг шулуун туулснаар төсөөлдөг. Цаг хугацаа ямар нэг зүйлээс эхлэн, ямар нэг зүйлд, жишээ нь, хөгжил тийш явж байдаг. Харин дорныхны хувьд цаг хугацаа тойргоор хөдөлж байдаг. Өөрөөр хэлбэл хүмүүний амьдрал ганцхан энэ амьдралаар дуусалгүй цикл хөдөлгөөнөөр мөнхөд үргэлжилж байдаг. Ертөнц дотогш гүнзгийрэх, хөгжлийг шаталсан байдлаар дорныхон сэтгэсээр ирсэн. Нэг амьдрал, нэг үндэстэн, нэг соёл хэзээ ч оргүй хоосноос шинээр үүсдэггүй бөгөөд тэрбээр нөгөөгөөс урган гарч байдаг юм.

3. Орон зайны ойлголт өрнөдийнхний хувьд харилцан холбоотой, хязгаарлагдмал байдаг. Жишээ нь европчуудын хувьд хил гэдэг бол хязгаар гэдэг утгаар ойлгогддог. Учир нь түүхэн-газар зүйн шалтгаанаар тэдгээрийн харилцаа холбоо хэтэрхий ойр, маш нягт байсан. Мөн түүхэн нэгэн үед Европ бүхэлдээ загалмайтны шашнаар амьсгалж, амьдарч, загалмайтны нэгэн төрийн доор нэгдэж байсан. Европчууд угсаа гарвалаараа хэн гэдгээсээ илүүтэй загалмайтнууд байсаар ирсэн. Харин дорны соёл иргэншлүүдэд орон зай хэзээд хязгааргүйгээр ойлгогдсоор ирсэн бөгөөд тэдний сэтгэхүйд хилийн тухай ойлголт Европынх шиг хөгжөөгүй.

А.Тойнбигийн үнэлэлтээр соёл иргэншил бүр ямар нэг дуудлагын хариу болж байдаг². Дуудлага нь өөр соёл иргэншил, гадаад орчин гэх мэт байна. Оросын соёл иргэншил монголчуудын байлдан дагуулалтад хариу болж бүрэлдсэн. Тэд богино хугацаанд төвлөрсөн улсаа байгуулж, Византитай дотносож, үнэн алдартны шашнаар эргэлт буцалтгүй амьсгалж, Өрнөдтэй нэг мөр хагаралд орсон. Ингэснээр тэд нэг шашинтай боловч өрнөдийн хувьд харийн мэт үнэлэгдсээр ирсэн бөгөөд оросууд ч өөрийн биеэ даасан байдал, онцлогоо хадгалсаар ирсэн юм. Энэ талаар А.Тойнби өөрийн онолын үндсэн бүтээл болох “Түүхийн ололт” номдоо сонирхолтой дүгнэлтийг хийсэн байдаг. Тэрээр “...1237 онд эхэлсэн гэнэтийн өдөөлт, дуудлага болох Монголын хан Батын Орос руу

² А.Дж.Тойнби., “Постижение истории”, М.2002г., стр 125

хийсэн алдарт аян дайн хүчтэй бөгөөд урт хугацааны байсан юм. Энэ нь дуудлага хэдий чинээ хүчтэй байна, түүнд өгөх хариу төдий чинээ давтагдашгүй бөгөөд үр өгөөжтэй байдгийг нотолно. Орост энэхүү хариулт нь амьдралын цоо шинэ хэв маяг, нийгмийн шинэ байгууллаар хэрэгжсэн...” гэжээ.³

XIX зууны дундаас XX зууны эхэн хүртлэх үеийг хамарсан колоничлолын 2 дахь их давалгаанаар дэлхийн газар нутгийн ихэнх хэсэг Европын колони болж хувирсан. Анх XVI зуунаас эхэлсэн колоний дайнд европчууд шууд хүч хэрэглэхээс өмнө, ямагт соёл иргэншлийн довтолгоог хийсээр ирж, өөрийн үнэт зүйлийг дэлхийгээр түгээн тархаасан. Энэ бүхэнд шинэчлэл, аж үйлдвэрийн дэвшил, үзэл санааны үнэт зүйл нь нөлөөлсөн. Гэвч энэ үеэс өрнөд өөрөө өөрийн нөлөө, онцлогийг алдаж эхэлсэн. Өөрөөр хэлбэл, тэдний хувьд нар жаргасан. Харин дорно соёл иргэншлийн довтолгоон бүрийд өөрийн өнгө аяс, онцлогоор хариу барьсаар ирсэн. Дээр өгүүлсэнчлэн өрнөд олон улсын харилцааг бүхэлд нь хянахдаа шинээр оролцогчдыг шинэчлэх нэрийн доор, хүчээр өрнөджүүлэх бодлого явуулж, харин дорно өөрийнхөөрөө хариулсаар ирсэн. Өнөөдөр олон улсын харилцаанд төв рүү тэмүүлэх өрнөджүүлэх бодлогын эсрэг дорно ямар хариу өгсөөр ирснийг судлахад доорх 3 төрлийн загвар гарч ирлээ.

Барууны шинэчлэл, вестернизацид дорно ямар хариу өгөх вэ?

1. *Дайран орох буюу Японы загвар.* Бүх гадны, харийн бүхнийг үгүйсгэх аргагүй юм гэж шинто шашинтангууд үздэг бөгөөд энэ загвараар өөрийн үнэт зүйлийг, онцлогийг хадгалангаа маш хүчтэй шинэчлэл явуулж, хөгжиж болохыг Япончууд Мэйжигийн хувьсгалаас хойш үзүүлж чадсан. Тэд өрнөдийн хөгжилтэй япон үндэстэн хэвээр үлдсэн.
2. *Кемализм буюу Туркийн дэвшилийн загвар.* Товчоор хэлэхэд энэ загвар баруунжина, боловсрон шинэчлэгдэнэ гэсэн утгатай. Өрнөдийн загвараар, өөрийн соёл иргэншлийн уламжлалт үнэт зүйлсээ өөрчлөх, даван туулах зорилготой. Мустаф Кемаль Ататюркийн хувьсгалаас хойш лалын Турк бага багаар Европын тогоонд багтахыг эрмэлзэх болсон бөгөөд ингэхдээ бүдүүлэг хоцрогдсон гэдэг нэрийн доор хөгжлийн гол саадаа гэж үзэцгээсэн лалын соёл иргэншлээсээ

³ Мөн тэнд., стр.147

татгалзаж, өрнөдийн соёл иргэншилд дэвшин орох бодлого явуулсаар өнөөг хүрэв.

3. *Өөрийн замаар шинэчлэгдэх буюу Ираны загвар.* Өөрийн соёл иргэншил, үнэт зүйлсийг хадгалах, түүндээ өөрийн онцлог бүхий шинэчлэлийг хийх. 1978 оны Иранд өрнөсөн Хомейнигийн хувьсгал бүхэлдээ хүчээр өрнөджүүлэхийг оролдож байсан өрний соёл иргэншлийн дуудлагад өгсөн хариу байсан юм. Тэд өрнөдийн гэх бүгдээс татгалзаж, өөрийн хөгжлийн, шинэчлэлийн загварыг сонгосон бөгөөд энэ хугацаанд олон улсын харилцаанд өрнөдийн их гүрнүүдийн зүгээс хориглолтонд орсон боловч бусад оролцогчдын зүгээс дэмжлэг хүлээсээр ирсэн гэж хэлж болно. Шинэчлэлийг зөвхөн өрнөдийн загвараар бус өөрийн онцлогтойгоор хийж болдгийг тэд харуулсан.

С.Хантингтон өөрийн “соёл иргэншлийн мөргөлдөөн”-дөө “хүйтэн дайн”-ы дараа, хоёр туйлын тэмцэл, хоёр үзэл санааны төгсгөлд дэлхийн хөгжлийн зүй тогтол соёл иргэншлийн мөргөлдөөнд хүрнэ гэж үзсэн бөгөөд “хүйтэн дайн” төгссөнөөр барууны үе, өрнөдийн үнэт зүйлсийн ноёрхол төгсөж байна гэсэн юм. Гэвч өнөөдөр олон шалтгаанаар Хантингтоны соёл иргэншлийн мөргөлдөөний цаг болоогүйг нотолж байна. Өрнөдийн соёл иргэншил шинэчлэгдсэн буюу америк төрхөөрөө дэлхийн бусад соёл иргэншлүүдийг, олон улсын харилцааны дэг журмыг тодорхойлсоор байна. Гэвч тэр бүрийд өрнөд өөрийн давуу байдал, бусдаас ялгарах онцлогоо нэгэнт алдсан, өөрөөр хэлбэл ямар ч үнэ цэнэгүй болсон гэж үзэж болно. Хэдий олон улсын харилцааны асуудлыг С.Хантингтон соёл иргэншилтэй холбон тодорхой авч үзсэн нь үнэн боловч А.Тойнби болон бусад нэрт эрдэмтэд ч өөрийн бүтээлдээ өрнөдийн нар жаргаж буйг, өрнөдийн соёл иргэншлийн хэт түрэмгий давшилтаас соёл иргэншлийн мөргөлдөөн гарч болзошгүйг маш тодорхой тайлбарласан байдаг.⁴

А.Тойнби соёл иргэншлийн болзошгүй мөргөлдөөнийг түүхчлэн тайлбарласан бол С.Хантингтон маш тодорхой бүр загвар, үзэгдэл (сценарит)-д оруулан хамгийн гол нь цаг үеэ олон тайлбарласан байдгаараа бусдын анхаарлыг татаж чадсан юм. Тэрбээр соёл иргэншлийн ялгаа гэдэг бол өөрөө маш гүн

⁴ А.Дж.Тойнби. “Цивилизация перед судом истории”, М.2003 г., стр.319

чанарын гэдэг ганцхан зүйлийг сайтар ойлгож чадсан учраас бие даасан онолыг гаргаж чадсан. С.Хантингтон соёл иргэншлийн ялгаа (хөгжлийн ялгаа)-ны логикийг мөргөлдөөнд аваачиж үзүүлсэн.

Олон улсын харилцаанд соёл иргэншлийн нөлөөг үгүйсгэж болохгүйн адил өрнөд бусад соёл иргэншлийг үгүйсгэж болохгүй юм. Дэлхий нэг боловч олон янз байна.

Өрнөдөд соёл иргэншлийн мөргөлдөөнөөс илүүтэй, бусад соёл иргэншил рүү довтлохоос илүү, бүх дэлхийн дэг журмыг зохицуулагч “цагдаа” болох хүслээс нь илүү “терроризм” хэмээх жинхэнэ бодит дайсан нэгэнт бий болсныг 9 сарын 11-ний гашуун өдрөөс хойш Өрнөд ойлгосон. Нөгөө талаар энэхүү үйл явдал нь “Хүйтэн дайн” хийгээд ЗХУ хэмээх түүний хүчтэй дайснаас хойш 10 жилийн дараа гарч ирсэн хамгийн боломжийн дайсан байсан бөгөөд түүний язгуур зорилгоо гүйцэлдүүлэх боломж олгосон дуудлага, “өдөөлт” байсан юм.

Анх 2001 оны 9 сарын 11-ний хэрэг явдал бараг л С. Хантингтоны зөв байсан мэт сэтгэгдлийг төрүүлж байсан ч өнөөдөр харин үйл явдал А.Тойнбигийн үнэлэлт зөв байж болохыг үгүйсгэхгүй байна. Өрнөд өөрийн шинэчлэгдсэн дүр төрхөөрөө (АНУ) дэлхийг дангаар хянан ноёрхох бодлоосоо салаагүй байгааг, хүчээр универсалчлах бодлого явуулсаар буйг Ж.Бушийн захиргааныхан сүүлийн хэдэн жилд Афганистан, Иракт явуулж буй дайн хийгээд Хойт Солонгост хандаж буй бодлогоороо нотлон байна. Тэр бүрийд Хятад, Лал, Орос, тэр байтугай хөгшин Европ ч түүний эсрэг байгааг тэрээр үл тоомсорлож байгаа юм. Сүүлийн жилүүдэд энэ мэтээр хэт их гүрэн олон улсын харилцааг дангаар тодорхойлох бодит оролдлогууд хийж буй нөхцөлд НҮБ тодорхой арга хэмжээ авч чадахгүй, цаг хугацаанаасаа хоцрох болж, түүнд чанарын шинэчлэл хийх шаардлагатай болсныг та анзаарч байгаа биз ээ. Энэхүү шинэчлэл олон улсын харилцааны бодит чиг хандлагыг тусгахын хамт түүхэн-соёл иргэншлийн хүчин зүйлсийг тооцвол илүү үр дүнтэй байх болов уу.

Эргэцүүлэл

Самуэл Хантингтон өөрийн онолоор олон улсын харилцаан дахь соёл иргэншлийн асуудал, үүрэгт анхаарлаа хандуулж, баруун өрнөдийн соёл иргэншилд тулгуурлан өөрийн нэг байдлыг тулгаж болохгүй, XXI зуунд дэлхий

олон өнгөтэй байх болно гэдгийг тодотгож өгсөн. Түүний онол “хүйтэн дайн”-аас хойшхи 1991-2001 оны бүсчлэн хөгжиж дэвжин цэцэглэж, даяаршин шаагиж асан олон туйлт ертөнцийн байдлыг тайлбарлаж зохицуулах хамгийн боломжийн үзэл баримтлал болж чадсан. Гэвч нөгөө талаас олон улсын харилцаанд соёл иргэншлийн асуудлыг хэт туйлшруулж болохгүй. Олон улсын харилцаанд үзэл суртлын, эс бөгөөс соёл иргэншлийн үзэл санааны зөрчилөөс илүүтэй эдийн засаг, улс төрийн зөрчил хүчтэй давамгайлж байна.

Нэг универсал соёл иргэншилтэй нэгдмэл нэг дэлхийн тухай бодол хэзээ ч бодит бус юм. Хүмүүс мянга мянган жилийн турш нэгийг нөгөөгөөс ялгагч ерөнхий төрхтэй байсаар ирсэн. Бүх дэлхийг хамарсан засаглал л бүх дэлхийн соёл иргэншлийг бий болгож болох юм. Ромын эзэнт гүрэн бараг ийм универсаль соёл иргэншлийг үүсгэж чадсан ч энэ нь эртний дэлхийн зөвхөн нэгээхэн хэсэгт л оршиж байсан.

Зөвхөн өрнөд ба лал хоорондын зөрчлийг өсгөж болохгүй юм. Энэ нь Ойрхи Дорнодыг, Лалын ертөнцийг түүхий эдтэй нь хянах гэсэн өрнөдийн бодлого туйлширч, улмаар “лал бол дайсан” гэсэн чиглэсэн мэдээлэл өрнөдийнхний сэтгэхүйд бодитоор хүрч үзэл сурталжсан хандлага болсны нэг илрэл юм. Лал өөр дотроо суннит ба шийтүүдийн урсгал гээд ихээхэн зөрчилтэй. Өрнөд С.Хантингтоны энэхүү мөргөлдөөнийг үүсгэхээс сэргийлэхийн тулд олон улсын харилцаанд “олон өнгө”-тэй оролцогчдыг эрх тэгшээр хүлээн зөвшөөрч, хүндэтгэн харилцах шаардлагатай болно.

С.Хантингтон нэгдмэл нэг дэлхийн хөгжил гэж байхгүй, харин соёл иргэншлийн хөгжил гэж бий. Өөрөөр хэлбэл, улс гүрнүүд тус бүрдээ өөрийн онцлогтой хөгжиж байна. Иймд өрнөд өөрийн үнэт зүйлийг экспортлох хэрэггүй гэж зөв дүгнэсэн юм. Харин түүнээс хамаагүй өмнө буюу “Хүйтэн дайн”-ы ид үед А.Тойнби өрнөдийг бас ийн шүүмжилж өрнөд дорнод руу болон бусад соёл иргэншил рүү довтолж асныхаа хариуг нэгэн цагт хүртэх болно гэж сануулсан байдаг. Тэрээр “..Манай эрин үеийн парадокс нь өрнөдийн соёл гэгээрлийн дүнд өрнөдөөс өөрөөс нь бусад бүх дэлхий хожсонд оршдог. Өнөөдөр ч бусад нийгэмлэгүүд зайлшгүй даван туулчихсан тэр л өнцгөөс, өөрийн хуучин, явцуу, туйлширсан хандлагаар өрнөд түүхийг харсаар байна. Тийм боловч эрт орой нэгэн цагт өрнөд өөрийн сургамжаа нэгэн үед өрнөдийн нөлөөний дүнд бусад соёл

иргэншлүүд дэлхийн нэгдэх явцад өртсөний адил хүртэх болно...”⁵ гэж хатуухан хэлсэн байдаг билээ.

Түүх төгсөөгүй. Дэлхий нэг цул биш. Соёл иргэншлүүд хүн төрөлхтнийг нэгтгэж, салгаж байдаг. Үнэмшил итгэл, гэр бүл, мах цус, ураг төрөл - хүмүүс энэ бүгдээр өөрийгөө нэгтгэж, энэ бүгдийн төлөө тэмцэж, оршин тогтнох болно.

Бидний хувьд

Даяаршлын шууд нөлөөгөөр дэлхий өөрөө улам бачим, нягт болж, янз бүрийн соёл иргэншлийн харилцан үйлчлэл улам нэмэгдэж, улмаар зөрчлийн хөрс өсөн тэлж байна. Нөгөө талаар олон улсын харилцаан дахь бас нэгэн хүчтэй үзэгдэл бол эдийн засгийн бүсчлэн хөгжих явц юм. Эдийн засгийн хөгжлийг даган нийгмийн өөрчлөлт хүчтэй өрнөж, энэ нь өрнөдийн соёлын экспорт нэг талаас хүчтэй давалгаалах, нөгөө талаас түүний эсрэг соёл иргэншлээр нэгдэх эхлэл болж болох юм. Мөн эдийн засгийн бүсчлэл хүчтэй өрнөхийн хэрээр эдийн засгийн нийтлэг сонирхол, үнэт зүйлс нь нэгэн нийтлэгийг бүрдүүлж байна. Гэвч соёлын онцлогийг өөрчлөнө гэдэг хүндрэлтэй.

Олон улсын харилцааны түүхийг эргэн харвал бусдад өөрийн үнэт зүйлийг наах гэсэн оролдлого нь хэзээд хүчтэй эсэргүүцэлтэй өртөж, томоохон хямралыг дагуулж байсныг өрнөд хэзээд мартаж болохгүй. Вьетнамын дайн, Ираны хувьсгалыг санавал АНУ-ын хувьд Ирак болон Афган дахь дайн хэзээ ч бүрэн төгсөхгүй юм.

Соёл иргэншил хоорондын уулзвар зурвасууд бий. Энэ нь нэг соёл иргэншлээс нөгөөд шилжих завсрын бүс гэж ойлгож болно. Лалын ертөнц өрнөдтэй ойр. Тиймдээ ч өрнөд түүхэндээ хэд хэдэн удаа дорнотой, лалтай зэвсэгт мөргөлдөөнд орж байсан бөгөөд өрнө ба лал хоорондын мөргөлдөөн нь харилцан “өдөөлт ба хариулт”-аар өрнөж байв. Анх өрнөдийнхөн загалмайтны аян дайнаар дорно руу, хожим Монголын аян дайнаар дорно, өрнөд рүү, Османы эзэнт гүрний эзэмшлийн төлөө өрнөд дорно руу довтолж байв. Эдгээр нь бүгд соёл иргэншлийн уулзвар зурвас дагуу өрнөж байсан. Хожмын Югославын дайн, Армян, Азербайджаны мөргөлдөөн нь хуучин социалист эвсэл задарснаар үүссэн ч, цаад

⁵ А.Дж.Тойнби. "Цивилизация переп судом истории", М.2003г., стр.318-319

шалтгаан нь соёл иргэншлийн уулзвар байснаар тодорхойлогдоно. Эндээс харахад мөргөлдөөн нь соёл иргэншлийн уулзвар зурвасын дагуу өрнөдөг гэж дүгнэж болно.

Ер нь олон улсын харилцааны хувьд соёл иргэншлүүдийн уулзвар дээр оршин буй Югослав, Орос, Казахстан, Украин, Турк гэх мэт улсуудын хувь заяа нь эмзэг, цаашид бүс нутаг, олон улсын харилцаанд нөлөөлөх хүчин их байдаг.

Соёлын зааг, соёл иргэншлийн огтлолцол дээр орших нэн хэцүү. Жишээ нь, Орос өөртөө түүхэн онцгой байр суурь олгохыг эрмэлзсээр ирсэн. Евразийг тэгнэн оршдог, олон үндэстний Орос бол зүрхэн улс. Үнэн алдартны шашинтай ч энэ нь өрнөдийн загалмайтны шашны өвөрмөц бие даасан урсгал, өмнө зүгтээ лалтай тулж байдаг, Евразийн соёлыг илүү тээгч. Энэ нь түүний соёл иргэншлийн огтлолцол дээр оршдог онцлогоор тайлагдана. Харин баруун Европт Франц, Герман гэх мэт аль нэг лидер, соёл иргэншлийн үнэт зүйлсийг тэргүүлэгч улс байхгүй юм. Мөн Арабын орнуудын хувьд ч гэсэн адил. Гэвч нөгөө талаар, соёл иргэншлийн уулзвар, огтлолцол дээр оршдог Орос мэт улс улс төрийн хувьд хэзээд тогтворгүй байдаг бөгөөд энэ нь эргээд үндэстний сэтгэлгээнд, дүр төрхөнд нь нөлөөлсөн байдаг. Орос нэг бол өрнөд рүү, эс бол дорно руу хазайсан гадаад бодлого явуулсаар ирсэн. Тогтворгүй байдал нь зөвхөн Оросын хилээр бус, Орос дотор болж буй үндэстэн хоорондын тэмцэл, жижиг үндэстний салан тусгаарлах үзэгдэл зэргээр илэрч байдаг. Тухайлбал, Чечений асуудал соёл иргэншлийн мөргөлдөөний нэг элемент юм. Орос мэтийн соёл иргэншлийн уулзварт оршдог улс орны элитийн үзэл бодлын тэмцэл зөрчил ч олон талаар улс төрийн ашиг сонирхлоос гадна соёл иргэншлийн далд шалтгаантай байдаг. Дотооддоо соёл иргэншлийн мөргөлдөөнийг үүсгэгч бодит хүчинтэй Энэтхэг, Пакистан зэрэг улсын хувьд энэ мөн адил хамаарна. Иймд аливаа олон улсын харилцааны асуудлыг, хямрал, мөргөлдөөнийг судлахдаа түүхэн явцыг соёл иргэншлийн мөн чанартай нь холбож үзвэл илүү үр дүнтэй шийдэл гарах магадлалтай.

Гол нь олон улсын харилцаан дахь соёл иргэншлийн зангилаа асуудлыг таньж мэдэхийн тулд соёл иргэншлийн философи, сэтгэлгээний бүтцийг нээн таних чадвартай байх хэрэгтэй байна. Жишээ нь, алс дорнодын соёл иргэншилд өвөг дээдсээ хүндлэн, хувь хүн нийгмийг өөрийн үнэт зүйлсийн түрүүнд тавьдаг зэрэг сэтгэлгээний онцлог ахуйд нь туссаныг хамтаар хөдөлмөрлөх, нийтээр

хооллох, бүлээр амьдрах зэргээс олж таньж болно. Өрнөдийн хувьд хувь хүний үнэт зүйлс түрүүнд байдгаас хамт олны дунд бие даасан байдлаа харуулахыг эрмэлздэг гэх мэтээр харьцуулан судалбал илүү үр дүнтэй байж болох юм.

Дэлхий олон өнгө будагтай. Үүнд өрнөд хүчээр санаагаа нялзаах эрхгүй юм. Бид ч энэ дунд өөрийн өнгөөр амьдрах хэрэгтэй.

Бид өөрсдийгөө нүүдлийн давтагдашгүй соёл иргэншилтэй гэж ярьж бичих дуртай байдаг боловч даяаршлын улбаагаар дэлхийн хөгжил хоёр урсгалаар орчиж буй үед даяаршин буй глобал ертөнцөд яаж өөрийн өнгө төрхийг хадгалан үлдэх, нөгөө талаас хэрхэн яаж бусдын алхааг гүйцэн дөхөж хоцрогдлоосоо салах тухай зэрэг бодох гарцаагүй шаардлага үүсч байна.

Монголчууд бид хоёр гүрний дунд түүхэн-газарзүйн шалтгаанаар түгжигдэн оршдог жижиг улс. Зөвхөн хоёр гүрнээр хашигдан байршаад зогсохгүй, Еврази, Хятад, Лалын соёл иргэншлээр хүрээлэгдэн оршдог. Түүхэнд монголчуудыг хоёр гүрэнд уусалгүй, харийн соёлын нөлөөнд авталгүй үлдэхэд нүүдлийн соёл иргэншил гол үүргийг гүйцэтгэсэн билээ. Гадны соёл иргэншлүүдээр хашигдан оршдог, хил залгаа томоохон улсуудын аюулд өртөж ирсэн жижиг улс нь ихэнхдээ өөрийн өвөрмөц соёл, соёл иргэншлийг түүхэн урт хугацаанд хадгалан үлдсэн байдаг нь ажиглагдсан. Тухайлбал, иудейн Израиль, нүүдлийн соёл иргэншилт Монгол г.м.

Бид 1990 оноос хойш нээлттэй гадаад бодлого явуулан бүх талын идэвхтэй гадаад харилцааг хөгжүүлж ирсэн ч нүүдлийн давтагдашгүй соёл иргэншилтэй улс хэмээн сэтгэхүйн талаас өөрөө өөрийгөө зарим талаар гадаад ертөнцөөс таслан түгжиж байх шиг. Манай улсын зүй ёсны бахархал нь дахин давтагдашгүй нүүдлийн соёл мөн боловч дэлхийн хөгжилтэй, ялангуяа бүсийн интеграцлалд орох боломжийг нүүдлийн сэтгэхүй хааж байж болохыг үгүйсгэхгүй байна.

Нэг талаар жижиг улсын хувьд өөрийн бие даасан байдлыг хадгалан үлдэх боломжийн тайлбар энэ мөн боловч нөгөө талаас олон улсын харилцаанд идэвхтэй оролцох, наад зах нь бүс нутгийн хэмжээнд идэвхтэй харилцах боломжийг хааж буй цаад шалтгаануудын нэг нь байхыг үгүйсгэхгүй. Энд нүүдлийн соёл, монгол бичгээсээ татгалзаад маргаашнаас ханз бичигт суралцан, хятад хэлэнд шамд, англи хэлээр ярилцан, америкаар сэтгэх гэсэн үг үгүй бөгөөд гагцхүү хамтран

түншлэх бүс нутгийг сонгохдоо геополитикийн хүчин зүйлсээс гадна, соёл-түүхийн ойр холбоог бодолцвол зүйтэй болов уу гэсэн санааг гаргахыг хичээв.

1994 оны Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд тусгайлан заасан соёл иргэншлийн аюулгүй байдлыг хангах асуудал нь тэртээ тэргүй эдийн засгийн хувьд хөршүүдээсээ болон гадныхны зээл тусламжаас бүрэн хараат болчихоод байгаа өнөө үед зайлшгүй бодолцож явах, судлах асуудал мөн.

Нөгөө талаар түүхэн-нийгмийн харилцааны талаас нь үзвэл сүүлийн үед манайхны ихэд хошууран зүтгээд буй Зүүн (хойд) Азийн интеграцлалд монголчууд гүнзгий ороход төдийлөн харшлах зүйлгүй төдийгүй бусад бүс нутгаас илүү ач холбогдолтой байж болох соёл иргэншлийн шалтгаанууд байна гэж би хувьдаа үздэг⁶.

⁶ үз. Г.Баасанхүү, "Зүүн хойт Азийн соёл иргэншилд Монголын холбогдох нийтлэгүүд", "Зүүн хойд Азийн байдал, төлөв" УБ.2003 он., 275-288 тал